

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

А.ГАНСҮХ

**ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ИМПОРТЫН БАРАА,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙГ БУУРУУЛАХ (TLF)
ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

№ 2013/01

2013 оны 02-р сарын 14 -ний өдөр

Монголбанкны Ерөнхийлөгч, Зам тээврийн сайдын 2012 оны 10 сарын 26-ны өдрийн А-167/57 дугаар хамтарсан тушаалын дагуу дэд хөтөлбөрийн үр дүн, зорилгод ажлуудын биелэлтийг 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар дүгнэж, цаашид авах арга хэмжээг дараах байдлаар тодорхойлоо:

Нэг. Хүрэн үр дүн, ололт

1. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж хурдасгах зорилт бүрэн хэрэгжиж байна:
 - Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тогтсон хуваарийн дагуу тусгайлсан галт тэргээр гүйцэтгэж, ачаа эргэлтийг хурдасгалаа. Энэ үйлчилгээг 2012.10.29-ний 09:00 цагаас эхлүүлж, 2013.01.31-ний өдрийн байдлаар нийтдээ 189 галт тэрэг, 10'554 вагоноор нийт 611'444 тонн ачааг тээвэрлээд байна.
 - Импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төмөр замын үйлчилгээг сайжруулж, хэвшүүллээ. Энэ хүрээнд авто зам, төмөр замаар орж ирсэн ачааг сааталгүй сэлгэн ачих, ачилтыг бригадын зохион байгуулалтыг сайжруулах, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх, УБ хотод ирсэн ачааг гар утасны мессежээр хэрэглэгчдэд мэдэгдэх, “хаалганаас хаалганд” ачаа хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх, ачаалалтай өдрүүдэд нэмэлт галт тэргийг аялуулах зэрэг ажлыг зохион байгууллаа.
2. Төмөр замын тээвэрлэлтийн өртгийг бууруулах зорилтын хүрээнд төмөр замын хэрэгцээнд зориулан шатахуун импортлох, уг зардлыг санхүүжүүлэх зорилгоор дотоодын банкаар дамжуулан 22 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкнаас авах асуудлыг нийгэмлэгийн ерөнхий хорооны 2013.01.29-ний өдрийн хурлаар шийдвэрлүүлж, шатахууны импортын худалдааны гэрээг ОХУ-ын Роснеть компанитай байгуулах ажлыг хийж байна.
3. Тяньжин-Замын Үүд чиглэлийн тээврийг хөнгөвчлөх, төмөр замын салбарын хөдлөх бүрэлдэхүүний парк болон ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг үлдсэн 3 зорилт хуваарийн дагуу хэрэгжилтийн эхний шатандаа байна.

Хоёр. Тулгамдаж буй асуудал

1. Тяньжин-Замын Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчлөх чиглэлээр Монгол-Хятадын ЗГ хоорондын комисс, БНХАУ-ын Төмөр замын яаманд асуудлыг тавьсан хэдий ч БНХАУ-ын талын шийдвэр гаргалтын үе шатаас хамааран үр дүнд хүрэхэд ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт шаардлагатай болж байна.
2. УБТЗ ХНН-ийн Ерөнхий хорооноос тус компанийн санхүүгийн чадавхиас шалтгаалан 92 тэрбум/70 тэрбум төгрөгийн хөдлөх бүрэлдэхүүн, 22 тэрбум төгрөгийн шатахуун/ төгрөгийн зээл авч, 400 ачааны хагас вагон, 60 ачааны битүү вагон, 3 гол замын зүтгүүр, 3 сэлгээний зүтгүүрийг худалдан авахаар тогтсон. Нэмж 1000 вагон худалдан авч, үйлчилгээг үзүүлэх асуудлаар шинээр байгуулагдах нүүрсний тээвэр хийх аж ахуйн нэгжтэй эцэслэн тохиролцож шийдвэрлэх нь зүйтэй байна.
3. Ачааны терминалыг хөгжүүлэх улсын нэгдсэн бодлогыг яаралтай гаргаж, үүн дотроос дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Гурав. Цаашид авах арга хэмжээ

- Дэд хөтөлбөрийн хүрээнд дээр дурдсан 3 асуудлаас гадна дараах 2 асуудлыг энэ улиралд анхаарч ажиллана:
1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянах механизмыг эцэслэн тогтоож, хэрэгжүүлэх
 2. Дэд хөтөлбөрт оролцох шинээр байгуулагдах нүүрсний тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжийн оролцоог тодорхой болгон хамтран ажиллах

Хэрэгжилтийг дүгнэсэн

МОНГОЛБАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Валют, эдийн засгийн
газрын захирал

Д.Дэлгэрсайхан

УХИ0014

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ё.Манлайбаяр

УХА0444

№	Зорилт	Биелэлт	Тайлбар	Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	
				Зам тээврийн яам	Монголбанк
I Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж хурдасгана. (ЗҮ-УБ)					
1.1	Тусгай зориулалтын 2 галт тэргийг хатуу зурмагаар аялуулах,	100%	Тусгай зориулалтын галт тэргийг 2012.10.29-ний 09:00 цагаас эхлэн аялуулж эхэлсэн, 2013.01.31-ний өдрийн байдлаар ачааны хатуу зурмагт 189 галт тэрэг 10554 вагон, 611444 тонн ачаатай аялсан.	* Тусгай зориулалтын галт тэргийг үргэлжүүлэн явуулна.	-
1.2	Сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулан хурдасгах,	50%	Сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг зохицуулах тусгай журам боловсруулж дууссан. Батлагдах шатандаа явж байна.	* Замын-Үүдэд авто болон төмөр замаар тээвэрлэгдэн орж ирсэн хүнс, хялбар муудах ачаа, цемент, барилгын материал, чиглэгтэй бүх ачаануудад дараалалын дагуу саалгүй ачуулах ажлыг зохион байгуулах, * Ачих буулгах кран, техник тоног төхөөрөмжид сэлбэг хэрэгсэл нөөцөлж доголдол сааталгүй ажиллуулах боломж бүрдүүлэх, * Ачилтын баригадыг зөв зохион байгуулж саатал гаргахгүй ажилуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. * Сэлгээний ажил болон ачиж, буулгах үйл ажиллагааг зохицуулах тусгай журам боловсруулах.	-
1.3	Шинэ жил, цагаан сарын баяр зэрэг улирлын чанартай ачааллыг бууруулахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх,	100%	Улирлын чанартай ачааллыг бууруулахад чиглэж УБТЗ ХНН-ийн замын даргын 2013.01.25-ны өдрийн А-19 дугаар тушаалаар 7 ажлыг хэрэгжүүлэхээр батлан, мөрдөн ажиллаж байна.	* Улирлын чанартай ачааллыг бууруулах зорилгоор шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлнэ.	-
II Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулна.					
2.1	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртгийг бууруулах,	20%	* Ачааны вагоны эргэлтийг 2013 оны 1 дүгээр сард 3.66 хоногт буюу өнгөрсөн оны мөн үеэс 21%-иар бууруулсан. * Мөн давхар чингэлэгэн ачилтат галт тэрэг аялуулах боломжийг судалж байна.	* УБ-Замын-Үүд чиглэлд давхар чингэлэгэн ачилтат галт тэрэг аялуулах ажлыг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулах. * Ачаа тээвэрлэлтийн өртөгийг тооцох ажлын хүрээнд статистик тоон мэдээллийг сайжруулах, тооцоо судалгаа хийх.	Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртөг, түүнийг бууруулахад дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нөлөөллийг тооцон үнэлэх ажлыг гүйцэтгэх.
2.2	Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулан зээлийн шугам нээх, /Санхүүжилтийн хэмжээ: 22 тэрбум төгрөг/	70%	* Зам, тээврийн сайдын 2012 оны 76-р тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь 2012.12.20-ны өдөр УБТЗ ХНН-ийн хэрэгцээнд зориулж ОХУ-ын Роснефть НК болон РЖД НХН-аас шатахуун худалдан авахаар холбогдох зөвшөөрлийг авсан. * УБТЗ ХНН-ийн Ерөнхий хорооны 2013.01.29-ний өдрийн хурлаар шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулж Монголбанкнаас 22 тэрбум төгрөгийн зээл авахаар шийдвэрлэсэн. * Роснефтьтэй байгуулах гэрээнд Монголын талаас оруулах саналаа хүргүүлсэн.	* Санхүүжилтийг авахтай холбогдуулж банктай зээлийн гэрээ байгуулах. * Роснефть компанитай шатахуун худалдан авалтын гэрээ байгуулж 2013 оны 2-р сараас худалдан авалтыг эхэлнэ.	УБТЗ ХНН-ийн зүгээс банктайгаа гэрээ байгуулсны дараа Монголбанк нь тухайн банктай дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулж, санхүүжилтийг олгоно.
2.3	Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалт, хяналтыг сайжруулах,	70%	* УБТЗ ХНН-ийн холбогдох албан тушаалтнуудад Ачаа тээвэр, захиран хувиарлах хэлтсийн дарга нарт захиргааны арга хэмжээг авч тарифын бус зардлыг бууруулахад шинэ менежментийг нэвтрүүлж байна. * Мөн УБТЗ-ын бүтцийн шинэчлэлтийн талаар санал боловсруулах Ажлын хэсэг байгуулдсан.	УБТЗ-ын бүтцийн шинэчлэлт хийж, зохион байгуулалт, хяналтыг сайжруулна.	-

№	Зорилт	Биелэлт	Тайлбар	Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	
				Зам тээврийн яам	Монголбанк
III Тяньжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчилнө.					
3.1	Тяньжин боомтын шилжүүлэн ачилт болон бусад үйл ажиллагааг хурдасгах,	30%	Энэ ажлын хүрээнд холбогдох хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2012 оны 11 дүгээр сард болсон Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын Ажлын хэсгийн хуралд Тяньжин боомтын үйл ажиллагааг хурдасгах, ойртолтын мэдээ авах тухай санал өгсөн.	Төмөр замын хамтын ажиллагааны Хятад-Монголын ажлын хэсэг-ийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг нь сэргээж Тяньжин боомтын шилжүүлэн ачилт болон тээвэрлэлтийн хугацааг богиносгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.	-
3.2	Ачаа тээвэрлэлтийн хугацааг багасгах	10%			-
IV Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлнэ.					
4.1	Төмөр замын салбарын ачааны вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх /Санхүүжилт: 1000 вагоны худалдан авалтад 136 хүртэл тэрбум төгрөг/	50%	УБТЗ ХНН-ийн Ерөнхий хорооны 2013.01.29-ны өдрийн хурлаар хөдлөх бүрэлдэхүүний паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор ачааны 600 хагас вагон худалдан авах 70 тэрбум төгрөгийн зээлийг авах асуудлыг шийдвэрлэсэн.	Ачааны 600 вагон худалдан авах газрыг сонгон шалгаруулж 2013 оны 06-р сар гэхэд худалдан авалтыг хийж эхэлнэ.	УБТЗ ХНН-ийн зүгээс банктэйгаа гэрээ байгуулсны дараа Монголбанк нь тухайн банктэй дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулж, санхүүжилтийг олгоно.
4.2	Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, /Санхүүжилт: 20 зүтгүүр худалдан авалтад 95 хүртэл тэрбум төгрөг/	0%	Дулааны цахилгаан станцуудад уурхайгаас шууд нүүрс тээвэрлэх зорилгоор ЭХЯ-ны харьяанд шинээр аж ахуйн нэгж байгуулж, нүүрс тээвэрлэх зүтгүүр, вагон худалдан авах санхүүжилтийг тус хөтөлбөрөөр шийдвэрлэхээр ярилцсан.	Шинээр байгуулагдах аж ахуйн нэгжийн нүүрс тээвэрлэх зүтгүүр, вагон худалдан авах санхүүжилтийг шилжүүлэх	Хүлээгдэж байна.
V Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.					
5.1	Замын-Үүд, Улаанбаатар төмөр зам, авто замын ачаа тээврийн нэгдсэн терминалыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу өргөтгөх, /Санхүүжилт: 25 хүртэл тэрбум төгрөг/	30%	ТЭЗҮ-г боловсруулан батлах ажлын хүрээнд ачих буулгах зам талбай, техник хэрэгслийн тооцоо судалгаа хийж, эдийн засгийн үр ашгийг тооцох ажлыг хийж байна.	Судлагаа хийж дуусгана. Шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах асуудлыг шийдвэрлүүлнэ.	Хүлээгдэж байна.
5.2	Замын-Үүд Улсын хилийг терминал 3-тай холбосон автозамыг ашиглалтад оруулсан байх. /Санхүүжилт: 25 хүртэл тэрбум төгрөг/	10%	Асуудлыг судалж байна.	Одоогоор тодорхойгүй байна.	Хүлээгдэж байна.